

ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаарх тайлан, бодлогын газруудаас гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 17 зорилтын 69 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн /unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 17 зорилтын 69 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Хяналтад авагдсан 69 арга хэмжээний 42 арга хэмжээг яам толгойлон, 27 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба нийт 69 арга хэмжээний биелэлт **62.32** %-тай дүгнэгдэв.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл:

- Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,
- Эдийн засгийн бодлогын хүрээний 11 зорилтын 63 арга хэмжээний биелэлт 59.2 хувь,
- Засаглалын бодлогын хүрээний 3 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 100.0 хувь,

- Ногоон хөгжлийн бодлогын 2 зорилтын 2 арга хэмжээний биелэлт 85.0 хувь, хэрэгжүүлсэн нийт **69** арга хэмжээний биелэлтийг **62.32** хувьтай дүгнэлээ.

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО**
/2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо						Хэрэгжилт /хувь/
			100	90	70	50	30	Төлөвлөгдөөгүй	
Нэг. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	1	1	0	0	0	0	0	100.0
Хоёр. Эдийн засгийн бодлого	11	63	10	12	7	13	17	4	59.2
Дөрөв. Засаглалын бодлого	3	3	3	0	0	0	0	0	100.0
Тав. Ногоон хөгжлийн бодлого	2	2	1	0	1	0	0	0	85.0
Дүн	17	69	15	12	8	13	17	4	62.32

Дөрөв. Дүгнэлт.

1. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2022 оны 9 сарын байдлаар **62.32** хувьтай дүгнэснээс 15 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч 100 хувийн гүйцэтгэлтэй, 12 арга хэмжээ гол үр дүн гарч эхэлж байгаа буюу 90 хувь, 8 арга хэмжээ гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувь, 13 арга хэмжээ ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50 хувь, 17 арга хэмжээ боловсруулалтын шатанд буюу 30 хувь, ажил хийгдээгүй 4 арга хэмжээ байна.

2. Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэйгээр хэрэгжилт удааширсан, хангалтгүй хэрэгжилттэй ажлууд нэмэгдсэн тул цаашид авах арга хэмжээнд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Тав. Санал, зөвлөмж.

1. Төрийн байгууллагуудын хамтран хэрэгжүүлэгчээр тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг толгойлон хэрэгжүүлэх байгууллагаас гаргуулан авах, хэрэгжилт хариуцсан нэгжүүдтэй хамтран ажиллах албан хаагчдыг сонгож үүрэгжүүлэх шаардлагатай.

2. Салбарын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг тайлагнаж хэвших.

3. Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжтэй яамны хариуцсан нэгжүүд нягт, уялдаа холбоотой ажиллах, мэдээлэл авах болон хүргэх нэгдсэн цонхтой болох, хэрэгжилтийг сар бүр шинэчлэн авч хэвших шаардлагатай байна.

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн “Хэрэгжилтийг хангах, үр дүнг сайжруулах тухай” 03 дугаартай албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах;

5. Төрийн захиргааны удирдлагын газраас тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг (дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж) нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой байдлаар (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан) гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгүүдийн огноо, дугаарыг тодорхой бичүүлэх, үг үсэг, утга найруулгын алдааг засах;

6. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 1 дүгээр хавсралтад зааснаар Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг “сар бүр цахим системээр тайлагнана” гэж заасан. Иймд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулах хугацаанаас ажлын 3 хоногийн өмнө нэгтгэн боловсруулсан тайланг албажуулж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх;

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Б.Мөнхдөл

Үнэлгээ хийж дүгнэлт зөвлөмж гаргасан:
ХШҮДАГ-ын ахлах шинжээч

Х.Цэнд-Аюуш

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
/2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР/**

№	ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт Хөрөнгийн хэмжээ эх үүсвэр		Хэрэгжилтийн хувь
						2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
			4	5	6	7	8	9
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1	1.1.6. Нүүрс, бусад уул, уурхайн бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	1. Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд "Ногоон гарц" түр журмыг хэрэгжүүлнэ. Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	ГХЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ЭТТ	-	Худалдааны түнш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлж экспортыг нэмэгдүүлнэ. Нүүрс тээврийн жолооч нарыг БНХАУ-ын талын тусгаарлалтын бүсэд байршуулж, хонуулах ажлыг зохион байгуулж, нүүрс тээврийн жолооч нарыг дархлаажуулалтын вакцинд хамруулах.	Нүүрс, уул, уурхайн бусад бүтээгдэхүүний экспортыг эрчимжүүлэх хүрээнд Ногоон гарц" түр журам бүрэн хэрэгжсэн. 2022.10.27-ний өдрийн байдлаар 22,559.4 мян.тн нүүрс, 1,189.1 мян.тн зэсийн баяжмал, 3,824.4 мян.тн төмрийн хүдэр, баяжмал, 118.0 мян.тн цайрын баяжмал, 283.1 мян.тн хайлуур жоншны баяжмал, 16.9 тонн алт экспортод тус тус гаргаад байна. Нүүрс 125.3%, зэсийн баяжмал 98%, төмрийн хүдэр, баяжмал 73.6%, цайрын баяжмал 118.0%, хайлуур жоншны баяжмал 43.6%, алт 84.5%-ийн экспортын гүйцэтгэлтэй байна.	100
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
2	3.2.1. Стратегийн ач холбогдол бүхий ордуудын	1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд	2021 - 2024	"Оюу Толгой" ХХК	Далд уурхайд 2021 оноос 2022 оны 6-р сар хүртэл 800.5 сая	Далд уурхайн бүтээн байгуулалт 73 хувьд хүргэнэ. Далд уурхайг	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 73 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2022 оны 11-р сарын 01-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын	100

	эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлнэ:	уурхайг ашиглалтад оруулна.			ам.доллар зарцуулсан. 2022 онд 1257.3 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн.	ашиглалтад хүлээн авна.	ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-100%, далд уурхайн бүтээн байгуулалт 84%-д хүрсэн.	
3		2. "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ	322,939.3 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %- ийг, зээлээр 86.9%- ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ)	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 100 хувьд, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 64 хувьд, засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 51 хувьд хүргэнэ.	Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 80%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 93%-тай. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хэлэлцүүлж хүлээн авсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 80%-тай байна.	90
4		2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл	2020 - 2023	"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Jiangxi Naipu mining machinery and new materials" Co.ltd, "FLSmith Mongolia" ХХК	558,528.0 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 36%- ийг, зээлээр 64%- ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ)	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 73 хувьд хүрнэ. Жилийн хүдэр боловсруулах хүчин чадал 35 сая тонн хүртэл өсгөнө.	Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн.	100
5		2.4. Засварын механикийн заводын	2020 - 2024	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	28,452.8 Гадаад, дотоодын	Засвар, механикийн заводын	Ажлын гүйцэтгэл өмнөх сарын түвшинд.	50

	өргөтгөл, шинэчлэл			хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 22%- ийг, зээлээр 78%- ийг ("Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ)	өргөтгөл, шинэчлэлийг 39%-д хүргэнэ. Уул уурхай, хүнд үйлдвэр болон бусад салбарын шаардлагатай бүтээгдэхүүн үйлдвэрлэн, бүс нутгийн болон Монгол улсын металл бүтээгдэхүүний зохих түвшний хэрэгцээг хангахуйц үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болох.		
6	3. Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулна.	2021 - 2024	"Эрдэнэ цагаан суварга" ХХК	796,678.0 сая төгрөг.	Бүтээн Бүтээн байгуулалтын ажил 93 хувьтай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөрөөмжийн угсралт хийж дуусах, туршилт, тохируулгын ажлыг хийх, баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.	Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж өнгөрсөн онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай байна. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Ажлын гүйцэтгэл өмнөх сарын түвшинд.	0
7	4. Багануур, Шивээ- Овоогийн нүүрсний уурхайд өргөтгөл хийж, олборлолтын	2020 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК "Багануур" ХК, "Шивээ-Овоо" ХК		"Багануур" ХК-ийн ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 100%, Шивээ-Овоогийн	Ажлын гүйцэтгэл өмнөх сарын түвшинд.	70

		хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг, зардлыг бууруулна.				нүүрсний уурхайн үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 36%-д хүргэнэ.		
8		4.2. Шивээ-овоогийн нүүрсний уурхайн өргөтгөлийн үлдэгдэл хөрөнгө оруулалт.	2020 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК "Шивээ-Овоо" ХК	6794.1 сая.төг /Зээлийн шимтгэл, даатгал орсон дүнгээр/	Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 68%-д хүргэнэ.	2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн JBIC төслийн гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна. Төслийн хүрээнд 5 технологийн автомашин 60 тонны Komatsu HD465 мөн 2 PC1250 гидро экскаватор нийлүүлэгдэж 14787.7 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. 2022 оны эхний хагас жилийн байдлаар JBIC төслийн санхүүжилтийн хэрэгжилт 37.6 хувийн биелэлттэй буюу 5.6 тэрбум төгрөг төлөөд байна. Шивээ Овоогийн уурхайг түшиглэн барих 200 мВт-ын цахилгаан станцтай холбоотойгоор конвейерийн систем, төмөр замын дотоод тээврийн төсөл бүхэлдээ шийдвэрлэгдэнэ.	90
9		5. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэнэ.	2020 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК		Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 10%-д хүргэнэ.	2022 оны хагас жилийн байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн. БНХАУ-н Гашуун сухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой компанийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул тус ажил нь тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	30
10		5.2. Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт.	2020 - 2022	"Эрдэнэс Монгол" ХХК	500.0 сая төгрөг	Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалт 100% хувьд хүргэх.	Эрдэнэс Монгол ХХК-ийн саналыг үндэслэн тус яамнаас 2021 онд Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны төсвийн төслийн ТЭЗҮ, зураг, төсвийн жагсаалтад Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд шаардлагатай туршилт, судалгааны ажлыг тусгуулахаар санал хүргүүлсэн. 2022 оны төсвийн төсөлд 1.0 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. УУХҮЯ-наас "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардагдах ТЭЗҮ, судалгаа" төсөл, арга хэмжээнд батлагдсан хөрөнгийг тус ордод нарийвчилсан хайгуулын ажил хийж, нөөцийг тодотгох арга хэмжээний зардалд шилжүүлэх тухай хүсэлтийг БХБЯ-нд	0

						хүргүүлсэн. БХБСайдын 2022.03.03-ны өдрийн 1/856 дугаар албан бичигт Улсын Их Хурлын Байнгийн хорооны 2022 оны "Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай" 01 дүгээр тогтоолын 3-т Асгатын мөнгөний ордод нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хариуцуулсан заалт болон холбогдох хуультай нийцэхгүй байх тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.	
11	5.3. Асгатын мөнгөний ордын нэмэлт хайгуулын ажлын хөрөнгө оруулалт.	2021 - 2024	"Эрдэнэс Монгол" ХХК	1000.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Нэмэлт хайгуулын ажлын гүйцэтгэл 33 хувьд хүргэнэ.	Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн (О.Хуланд) даалгасан. УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/801 дугаар албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон. "Эрдэнэс Монгол" ХХК-иас ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө ирүүлээгүй байна.	0
12	6. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2021 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	640,188.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтцийг бүрдүүлж, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажил 40 хувьд хүргэнэ.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 44.9%-тай байна. Загийн усны хоолой усан хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7%-д хүрсэн.	70
13	6.1. 3.2.1.6.1. Техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт.	2020 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	2022 оны хагас жилийн байдлаар 86.0 тэрбум төгрөг зарцуулсан.//	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 11%-д хүргэнэ.	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Уулын үндсэн техник худалдах, худалдан авах гэрээний дагуу 2022 оны 12 дугаар сард 1 дүгээр ээлжийн техник, тоног төхөөрөмжийг хүлээн авахаар бэлтгэж байна.	90
14	6.2. 3.2.1.6.2. Конвейерийн системийн	2021 - 2024	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	2022 онд 99.30 тэрбум төгрөг зарцуулахаар	Цанхийн баруун уурхайн хөрсний конвейерийн	Конвейерын системийн ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн инженерүүд гүйцэтгэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10	30

		хөрөнгө оруулалт.			төлөвлөсөн. /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр//	систем нэвтрүүлэлт 22 хувьд хүргэнэ.	дугаар сарын 04-ны өдрийн А/249 дугаар тушаалаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсгийн шүүмжийг нэгтгэн урьдчилсан байдлаар 2022.10.20-ны өдөр Цахимаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн. Шинжээчдийн шүүмжийг хүлээн авч холбогдох засварын ажлыг гүйцэтгэж байна.	
15		6.3. 3.2.1.6.3. Нүүрс баяжуулах үйлдвэр	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	2022 онд 355.66 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын ажил 81%-д хүргэнэ.	Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн барилгын материалын татан авалтыг 2022 оны 10 дугаар сард хийж, суурь судалгааны ажлуудыг бүрэн дуусгасан. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд анхдагч нүүрс хадгалах агуулахын суурийн цутгалтын ажил явагдаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 20%-тай байна.	50
16		6.4. 3.2.1.6.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах.	2021 - 2022	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	38,126.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Ачилтын нэгдсэн төв байгуулах ажил 100%-д хүргэнэ.	Ачилтын нэгдсэн төв байгуулах төслийн гүйцэтгэл 44.9%-тай байна. Төслийн ажлын зураг төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектур болон холбогдох яам, тамгын газраар баталгаажуулах ажил хийгдэж байна.	50
17		6.5. 3.2.1.6.5. Усан хангамж шийдвэрлэх.	2021 - 2023	"Эрдэнэс-Тавантолгой" ХК	71,931.4 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/	Усан хангамжийн ажил 48.8 хувь.	Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан Өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах "Загийн усны хоолой"-н газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг боловсруулж, БХБЯ-ны харъяа Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ тайланг 2022 оны 9 дүгээр сард БОАЖЯ-ны зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "ЧММ" ХХК, "Эс Энд Эй Трейд" ХХК, "Набсан" ХХК-тай гэрээ байгуулан, барилга угсралтын ажил явагдаж байна. Одоогийн байдлаар: Гүний худгийн ажил 51%, Ус цуглуулах шугамын барилга угсралт 11%, Усан сангийн барилга угсралт 76%, Ус дамжуулах гол шугамын барилга угсралт 46%, Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 68%-тай тус тус гэрээний дагуу гүйцэтгэгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 48.8%-тай байна.	100

18	3.2.2. Томоохон ордуудыг ашиглалтад оруулж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ:	1. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглана.	2021 - 2024	"Эрдэнэс силвер ресурс" ХХК		Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэнэ.	Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бараа материал, тоног төхөөрөмжийн хомстол үүсч, татан авалт удааширсны улмаас Баяжуулах 2 дугаар үйлдвэр төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оролгүй хойшилсон. 2022 оны 10-р сарын байдлаар 92.6 мян.тн хүдэр олборлож, 33.5 мян.тн хүдэр, 1.97 мян.тн баяжмал борлуулж, 45.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.	90
19		2. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна.	2021 - 2024	Монголросцвемет ТӨҮГ	2022 оны хагас жилийн байдлаар 39.5 тэрбум төгрөг зарцуулсан	Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулна. 100 хувьд хүргэнэ.	Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг эхлүүлэн 2022 оны 10 дугаар сарын байдлаар 1043,0 у.м уулын ажил хийж 82% гүйцэтгэлтэй, дэд бүтэц цахилгаан дамжуулах агаарын шугам барих болон кэмгийн барилга байгууламжийн ажил 80% гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022 оны 09-р сарын 28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгөөд байна.	90
20	3.2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх геологи, судалгааны ажлыг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 47%-ийг хамруулна	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 10,587.4 Гүйцэтгэл: 8,125.1 Санхүүжилт: 5,211.5	Нутаг дэвсгэрийн 45%-ийг хамруулах, ашигт малтмалын хэтийн төлөвтэй 18 талбай ялгана.	Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Бүрхтэй уул-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022.06.02-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 17,787.84 км2 талбай буюу 1.13%, нийтдээ 43.1%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна. Эдгээр 6 төслийн судалгааны үр дүнд Мангирт (өнгөт металл P2 зэргээр Cu-2298.94 тн, мөнгө-7.248 тн, алт-2.352 кг, цайр-210 тн, хартугалга-315 тн), Эрдэнэ овоо (Алт шороо P1 зэргээр 65.5 кг), Хуурай сайр (P2 зэргээр алт-224.19 кг), Угалзын худаг (P2 зэргээр алт-1524.1 кг), Дөшийн ам (P3 зэргээр алт-80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (P1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (P1 зэргээр 26.1 сая тн), Далан шар уул (P3 зэргээр хром-526526 тн, никель-171515 тн), Дөш уулын төмөр зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг ялгасан. 2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан. 2. Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50	100

						<p>нийт 6 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталж төслүүдийн гүйцэтгэгчийг шалгаруулан зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж ажлыг эхлүүлсэн.</p> <p>4. Хээрийн судалгааны ажилтай 25 төсөлд шуурхай хяналтыг ҮГА-тай хамтран 8-9 дүгээр сард хийсэн.</p> <p>5. Үр дүнгийн тайлантай болон хээрийн судалгааны ажилтай 27 төслийн 2022 онд гүйцэтгэсэн ажлыг баталгаажуулан хүлээн авах ажлыг ҮГА-тай хамтран хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2022.11.22-ны байдлаар 13 төслийн хээрийн материалыг хүлээн аваад байна.</p>	
21	2. 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг эхлэх, нутаг дэвсгэрийн 0.15 хувийг хамруулна	2022 - 2024			Нутаг дэвсгэрийн 0.05%-д судалгааны ажлыг эхлэнэ.	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2022.03.07-ны өдрийн 03/577 дугаар албан бичгээр 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаадлагын төслийг боловсруулан 2022 оны II улиралд багтаан ирүүлэх тухай албан бичгийг ҮГА-нд хүргүүлсэн. Мөн Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн 2022-2023 оны санхүүгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус зааврыг боловсруулах саналыг хүргүүлсэн.</p>	30
22	3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах, нутаг дэвсгэрийн 100 хувь хамруулна	2021 - 2023	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 1,269.2 Гүйцэтгэл: 978.5 Санхүүжилт: 746.4	L, M /N/ хавтгай буюу нутаг дэвсгэрийн 60%-ийг хамруулна.	<p>Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан K хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын 2022 оны А/03 дугаар тушаалаар хүлээн авсан. Ингэснээр нутаг дэвсгэрийн 14.1%-ийг 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийн нэгтгэлд хамруулсан бол L хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаснаар нутаг дэвсгэрийн 60%-ийг судалгаанд хамруулсан бөгөөд L хавтгайн үр дүнгийн суурин боловсруулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна. Харин M хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг үргэжлүүлэн гүйцэтгэсэн.</p> <p>Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлыг баталгаажуулан хүлээн авах ажлыг ҮГА-тай хамтран хэрэгжүүлж 2022.11.22-ны өдрийн байдлаар M хавтгайн хэмжээнд нэгтгэх төслийн хээрийн материалыг хүлээн аваад байна.</p>	90
23	4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 163.7 Гүйцэтгэл: 163.7 Санхүүжилт:	Ховд-2020 төслийг үргэлжлүүлэх, нутаг дэвсгэрийн 66%-ийг	<p>1. Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.</p>	100

		ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийн 70 хувийг хамруулна			141.4	судалгааны ажилд хамруулна.	<p>2. Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулахаар ажиллаж байна.</p> <p>3. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг агаарын геофизикийн хэмжилтийн ажилд хамруулсан.</p> <p>4. 2022 онд агаарын соронзон болон спектрометрийн өндөр эрчимжилтэй гажлуудыг 14 талбайд шалгах газрын геофизикийн хэмжилтийн ажлыг төлөвлөн, геологийн маршрут, соронзон орон ба цацраг идэвхижилийн судалгааг төлөвлөсөн хэмжээнд хийсэн. Мөн петрофизикийн дээжүүд авч лабораторид шинжлүүлэхээр өгсөн ба ингэснээр төслийн хээрийн судалгааны ажил дуусгавар болсон. Төслийн ажлын үр дүнгийн тайлан боловсруулах ажил 2022.11-р сараас эхэлсэн бөгөөд 2023 онд үр дүнгийн тайланг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.</p> <p>5. Төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022.11.22-нд хүлээн авсан.</p>	
24		5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийг 100 хувь хамруулна	2021 - 2022	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 125.5 Гүйцэтгэл: 87.0 Санхүүжилт: 64.2	Нутаг дэвсгэрийн 100%-д Геохими-2019 судалгааны ажлыг хийж дуусган, үр дүнг хүлээн авна.	<p>1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайг буюу 32.1%-ийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулсан бөгөөд 2019 оноос Монгол орны нутаг дэвсгэрийн үлдсэн хэсэгт уг судалгаан ажилд 100% хамруулахаар хэрэгжүүлж эхэлсэн. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаагаар хамруулан холбогдох дээжлэлтийг авч дууссан.</p> <p>2. 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнгээр боловсруулах тайлангын суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн.</p> <p>3. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан.</p> <p>4. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын анхдагч баримт, материалыг ҮГА-тай хамтран 2022.11.11-нд хүлээн авсан.</p>	100
25		6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи,	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 2,137.7 Гүйцэтгэл:	Эрдэнэт хотын судалгааны үр дүнг хүлээн авах, Дархан, Ховд хотын	<p>1. 2022 онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан, Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геоэкологи-2019, ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021 болон Хангай, Хөвсгөл, Хэнтийн районы халуун рашааны геотермийн Гүний хагарал-1</p>	

		геотермийн судалгааны ажил хийнэ			1,719.6 Санхүүжилт: 1,184.2	судалгааг үргэлжлүүлэх, Чойбалсан, Даланзадгад хотын суурьшлын бүсэд судалгааны ажлыг эхлэх, Хангайн халуун рашаан геотермийн судалгааг эхлэнэ.	нэртэй төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлан ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3.2022 онд Улаанбаатар болон Эрдэнэт хотын эзэмшил газарт хийгдсэн судалгааны ажлын үр дүнг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 4. ХО геозкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн хээрийн судалгааны ажилд 8-р сард шуурхай хяналтыг хийсэн. 5. Үндэсний геологийн албатай хамтран ДА геозкологи-2020, ХО геозкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн 2022 оны суурин болон хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг баталгаажуулан хүлээн авах ажлыг 2022.11-р сард багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөн 2022.11.22-ны өдрийн байдлаар ХО геозкологи-2021 хүлээн авч, ДА геозкологи-2020 төслийн материалыг хүлээн авахаар Дархан хотод томилолтоор комисс томилон ажиллуулж байна.	50
26		7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 2,280.1 Гүйцэтгэл: 1,283.7 Санхүүжилт: 705.0	Тек-2021, ТЗ-2021 төслийг үргэлжлүүлэх, энергийн түүхий эдийн хэтийн төлөв /ЭТЭ-2022/ төслийг эхлүүлнэ.	1. 2022 онд Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан Мезозой, Кайнозойн насны хурдас чулуулгийн тархалт, тогтоц, түүнтэй холбоотой үүссэн ашигт малтмалын минерагенийн судалгааны Мезо-Кайнозой-2021 болон шинээр хэрэгжүүлэх Монгол Улсын босоо тэнхлэгийн дагуух нутгийг хамарсан геологийн орчин, тогтоцын судалгааны Гео орчин-2022, Баруун Монголын шатах ашигт малтмалын хэтийн төлөвийг тогтоох БМШАМ-2022, Монгол орны алтны металлогенийн зураг зохиох Мета-алт-500 төслийг төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн дэд сайд баталсан. 2 Мезо-Кайнозой-2021 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар 3-р сард хэлэлцүүлсэн. 3. Гео орчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зохион байгуулан хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулан судалгааны ажлыг 8-р сараас эхлүүлсэн. 4. Дээрх 4 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг хүлээн авч, баталгаажуулах ажлыг 2022.11.29-30-ны хооронд зохион байгуулахаар төлөвлөж байна.	50

27		8. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажил хийнэ	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 245.6 Гүйцэтгэл: 182.0 Санхүүжилт: 137.4	ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-тай хамтарсан геологийн судалгааны ажлын 5-р үе шатны ажлыг үргэлжлүүлэх, бусад орнуудтай харилцан үр ашигтай төсөл эхлүүлнэ.	1. МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ-ын хамтарсан төслийн 5-р үе шатны ажлын 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж хээрийн болон суурин боловсруулалтын ажлыг эхлүүлсэн. 2. Төслийн 2022 оны суурин боловсруулалтын ажлын материалыг ҮГА-тай хамтран 2022.11.15-нд хүлээн авсан.	90
28	3.2.4. Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахим системийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.	1. Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан төслийг магматизм, стратиграф болон бусад геологийн мэдээллээр бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 550.0 Гүйцэтгэл: 336,4 Санхүүжилт: 122.0	Үндэсний геомэдээллийн нэгдсэн сан хөтөлбөрийн төрөлжсөн мэдээллийн сан төслийг үргэлжлүүлэх, ажлын явц 60%.	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж, хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 3. Төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлыг хүлээн авч, баталгаажуулах ажлыг 2022.11.30-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөж байна.	30
29		2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 550.0 Гүйцэтгэл: - Санхүүжилт: -	Геологийн чулуун дээжийн сан болон цахим архив бүрдүүлэх төслийг эхлүүлэх, ажлын явц 60%.	1. 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 2. Чулуун дээжийн сан-1-2022 болон Цахим архив-1-2022 төслийн ажлын хэмжээ, арга, аргачлал болон тухайн төслийн онцлогоос хамаарч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд заасны дагуу тендерт оролцох сонирхолтой зөвлөх хуулийн этгээдийн тоо 3 ба түүнээс дээш байх шаардлагыг хангаж хураангуй жагсаалт үүсгэхгүй байгаа тул сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулж 11.04-нд нээж, 11.18-нд санхүүгийн саналыг нээн хамгийн сайн оролцогчоор шалгарсан болон шалгараагүй оролцогч нарт мэдэгдлийг хүргүүлсэн.	50

30	3.2.5. Өндөр технологийн түүхий эд болох газрын ховор элемент, үнэт, өнгөт, хар, холимог металл, металл бус ашигт малтмал болон газрын	1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 1,087.3 Гүйцэтгэл: 550.3 Санхүүжилт: 235.9	ГХЭ болон өндөр технологийн түүхий эдийн төрөлжсөн судалгааны төсөл хэрэгжүүлнэ.	1. Стратегийн ашигт малтмал (ГАСАМ)-ын судалгааны ажлын үр дүнг цар тахлын нөлөөнөөс шалтгаалан 2021 онд хүлээн авах боломжгүй болсон бөгөөд 2022 онд хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан. 2. ӨТТЭ-1-2021 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. 5. Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022.11.15-11.17-нд хүлээн авсан.	90
31	тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн нөөцийг арвижуулна.	2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө	2021 - 2024	УУХҮЯ	Улсын төсөв Батлагдсан: 8,599.9 Гүйцэтгэл: 5,036.0 Санхүүжилт: 2,869.7	Үнэт, ховор, холимог металлын чиглэлээр эрэл, үнэлгээний ажлын үр дүнг хүлээн авах, өнгөт, хар металлын судалгааг үргэлжлүүлэх, хэтийн төлөвийн үнэлгээ өгнө.	1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан. 2. Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. 3. Эрэл үнэлгээ-4-2022 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж хамгийн сайн оролцогчоор шалгарсан хуулийн этгээдтэй зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. 4. Төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг 8-9 дүгээр сард хийсэн. 5. Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран хүлээн авсан. Бусад 3 төслийн хээрийн	70

							материалыг 11-р сард багтаан хүлээн авахаар ажиллаж байна.	
32		3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, хайгуулын ажлыг эрчимжүүлэн геологийн нөөцийг өсгөнө	2021 - 2024	УУХҮЯ, АМГТГ	Төсөв тусгагдаагүй	Ашигт малтмалын хайгуулын 60-80 тусгай зөвшөөрөл шинээр олгон, хайгуулын ажлыг эрчимжүүлж геологийн нөөцийг өсгөнө.	- Шинэчилэн батлагдсан “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох хууль эрх зүй, талбайн геологийн мэдээлэл болон цахим хэлбэрээр явуулах www.tender.gov.mn платформ зэрэг бэлтгэл ажил бүрэн хангагдсан бөгөөд 25 талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор 2022.11.23-ны өдөр tender.gov.mn платформ-оор зарласан. Цаашид 7 хоног тутамд 25 талбайг дээрх платформуор дамжуулан зарлахаар бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	90
33	3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй	1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цэгцэлж, олон нийтэд нээлттэй болгоно.	2020 - 2022	УУХҮЯ, УУБГ, ГБГ	Төсөв тусгагдаагүй	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажил 100%.	УУХҮСайдын 2022.10.27-ны өдрийн А-273 дугаар тушаалаар холбогдох мэргэжлийн холбоод, салбарын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллагууд оролцсон хэлэлцүүлэх зохион байгуулах, танилцуулах, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулах, холбогдох яамдаас санал авах, Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулан ажиллаж байна.	50
34	болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.	2. Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно.	2020 - 2024	УУХҮЯ, УУБГ	2500.0 сая төгрөг	Засгийн газрын шийдвэрийн дагуу уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг байгуулна.100 хувьд хүргэнэ.	Уул уурхайн судалгаа, хөгжлийн төв байгуулах талаар Засгийн газрын тогтоолын төсөл болон төрийн өмчит аж ахуйн тооцоот газрын дүрмийн төслийг боловсруулсан бөгөөд холбогдох тооцоо, судалгааг яамны удирдлагад танилцуулсан. Өмнөх сарын түвшинд.	30
35		3. Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, УУБГ	818.6 сая төгрөг	Засгийн газрын шийдвэрийн дагуу орон нутагт эрдэс баялгийн	Засгийн газрын 2022 оны 295 дугаар тогтоолоор Ашигт малтмал, газрын тосны газрын орон нутаг дахь төлөөлөгчийн газрыг байгуулахаар болсон.	100

						асуудал хариуцсан нэгж байгуулагдана. 100 хувьд хүргэнэ.		
36		4. Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, УУБГ, ГБГ	Төсөв тусгагдаагүй		Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 болон түүнээс Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2021 оны ажиллах хүчний мэдээлэл болон уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тухайн төслийн техник, технологийн шаардлагаас хамаараад зарим мэргэжлийн инженер, техникийн гадаад ажиллах хүч, мэргэжилтэн шаардлагатай байдаг бөгөөд хүсэлтийг тус яамнаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэдэг Их, дээд сургуулиудын нэг болох Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-д бэлтгэгддэг Байгалийн нөөц, технологийн магистр /Master in Resources and Technology/-ын хөтөлбөрт тохирох индекс одоогоор байхгүй байгаа тул тохирох хөтөлбөрийн нэр, индексийг жагсаалтад бүртгүүлэх хүсэлтийг БШУЯ-нд хүргүүлсэн. Газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай инженер, техникийн ажиллагсадыг бэлтгэх ажлын хүрээнд ШУТИС, МУИС-иудтай хамтран сургалтын төлөвлөгөөг боловсруулж ШУТИС-ийн “Хөтөлбөрийн дэд хороо”, “Хөтөлбөрийн ерөнхий хороо”-гоор хэлэлцүүлэн Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлд оруулаад байна. Мөн “Газрын тосны инженерчлэл” бакалаврын хөтөлбөрт БШУСайдын 2022.05.09-ний өдрийн А/160-р тушаалаар 072407 тоот индекс авсан. Энэхүү хөтөлбөрийг 2022-2025 онуудад хэрэгжүүлэх бөгөөд 2022-2023 онд инженерийн чиглэлээр элссэн оюутнуудыг 4 жилээр, инженерийн чиглэлээр сурч байгаа 2-р дамжааны оюутнуудыг 2.5 жилээр, инженерийн суурьтай төгсөгчдийг 2 жилээр сургах бөгөөд 2022 оны 9 сараас элсэлт авахаар төлөвлөж байна. Тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	70
37	3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий	1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн	2021 - 2024	УУХҮЯ, "Кью эс си" ХХК, "Дархан		Төслийн удирдлага, инженеринг, тоног	Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засаг хөгжлийн яам /хуучнаар/ болон “Кью Эс Си” ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан “Уул	30

	эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ:	цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулна.		төмөрлөгийн үйлдвэр" ХК		төхөөрөмжийн угсралт суурилуулалт, барилгын ажлыг эхлүүлнэ. 61.7%	уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан. Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд "Шинэ сэргэлт-Монгол ган" хэлэлцүүлгийг 2022.07.04-ний өдөр зохион байгуулсан. Төслийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийлгэх, 2023 оны төсөвт суулгах хүсэлтийг УУХҮСайдын 2022.08.25-ны өдрийн 01/2288 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК нь БНХАУ-ын ММС СЕРI компанийн боловсруулсан "Монгол ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ-ийг ("Эрдэнэс судалгаа хөгжлийн төв" ХХК-тай 2022 оны 09 дүгээр сард байгуулсан гэрээний дагуу) шинэчлэн боловсруулж, төслийн ТЭЗҮ-д шинжээч томилж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2022.10.17-ны өрийн 01/941 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн. Тус ажлын хүрээнд УУХҮСайдын 2022.10.31-ний өдрийн А/278 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-д дүгнэлт гаргах шинжээчийн хэсгийг томилон ажиллаж байна.	
38		2. Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2022	УУХҮЯ, "Бэрэн групп" ХХК		Барилга, дэд бүтцийн ажлыг дуусгаж тоног төхөөрөмжийн худалдан авалт, угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгэнэ. 100%	"Бэрэн групп" ХХК болон түүний хамаарал бүхий компаниудын Хөгжлийн банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас 2022 оны 8 дугаар сард Хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн. Уг асуудлын хүрээнд шийдвэр гарч, барьцаа хөрөнгө өр, зээлийн асуудал шийдэгдэх хүртэл төслийн ажил зогсонги байдалд байна.	30
39		3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулна.	2020 - 2023			Гангийн үйлдвэрийн барилгын ажил, тоног төхөөрөмж татан авалт, угсралтын ажлыг гүйцэтгэж, түүхий эдийг татан авч	Төслийн нэмэлт хөрөнгө оруулалтын хувилбаруудыг судалж байгаа ба ковид-19 цар тахлын улмаас 2020 оноос хойш бүтээн байгуулалтын ажил зогсонги байдалд байна.	0

40		4. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.	2020 - 2022	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ		нөөцлөнө. 88% ҮТП-ийн авто зам, дулаан, ус хангамж, цахилгаан хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээг барьж байгуулна. 100%	<p>ҮТП-ийн авто зам, төмөр зам, усан хангамж, ариутгал татуургын системийн зураг, төсөл төсвийг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан бол цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100% гүйцэтгэж ЭХЯамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ус хангамж болон ариутгах татуургын системийг 2023 оны 6 дугаар сард, авто замыг 2023 оны 7 дугаар сард, төмөр замыг 2023 оны 8 дугаар сард, цахилгаан хангамжийн системийг 2024 оны 2 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж, дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна.</p> <p>- Автозам барьж байгуулах ажлын тендер нь 2022.06.30, 2022.09.26-ны өдөр 2 удаа зарлан, шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул тендерийг 2022.11.07-ны өдөр дахин зарласан.</p> <p>- Төмөр зам барьж байгуулах ажлын тендерийг 2022.10.06-ны өдөр нээхэд 3 компани материал ирүүлсэн боловч шаардсан материал дутуу ирүүлсэн тул тендер хүчингүй болсон, тендерийг 2022.11.07-ны өдөр дахин зарласан бөгөөд 2022.12.12-ны өдөр нээхээр ажиллаж байна.</p> <p>- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендер 2022.10.06-ны өдөр нээсэн бөгөөд нийт 7 оролцогчийн ирүүлсэн материалд үнэлгээ хийгдэж дууссан ба шаардлага хангах оролцогч байгаагүй тул мэдэгдэл хүргүүлэн, дахин зарлахаар ажиллаж байна.</p> <p>- Паркийн цахилгаан хангамжийн ЭЗҮ-ийг ЭХЯ-ны ШУТЗ-өөр батлуулсан, ДҮТ-ээр горимын тооцоо хийгдсэн. Техникийн нөхцөлийн зөвшөөрлийг авсан бөгөөд нарийвчилсан зураг төслийг боловсруулах техникийн даалгавар боловсруулсан, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан тендер зарлахаар ажиллаж байна.</p> <p>- Засгийн газрын "Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай" 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн засаг дарга хооронд 2022.10.25-ны өдөр байгуулж, тус гэрээний дагуу "Эрдэнэ үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн байгуулагдах үйлдвэрлэл, технологийн паркийн 2022.11.14-</p>	30
----	--	---	-------------	-------------------------------	--	---	--	----

41		5. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина.	2020 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	13,340.1	Үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийнэ. 50%	<p>ний өдрийн №000000019 дугаартай Газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр авсан.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг үндэслэн "Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах" ажлын техникийн даалгавар боловсруулж, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Үйлдвэрлэл технологийн паркийн төслийн нэгжийн захирлын 2022.09.22-ны өдрийн "Худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай" 69/29 дугаар албан бичгээр Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны газрын даргад хүргүүлсэн бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.08.08-ны өдрийн А/482 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо тендер зарлахаар ажиллаж байна.</p> <p>ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээ"-ний тендерийг 2022.11.02-ны өдөр нээж үнэлгээг хийж, Эс Ай Си Эй байгууллагад гэрээ байгуулах эрх олгоод байна.</p> <p>ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх ажлын тендерийг 2022.11.16-ны өдөр нээсэн бөгөөд Үнэлгээ хийгдэж байна.</p> <p>Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-ийн үйлдвэрийн судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ын гэрээг ШУТИС-ийн УУХ, ГУУС-тай 2022.09.13-ны өдөр байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2022.11.04-ний өдөр ирүүлсэн эхний тайланд Ажлын хэсгийн дүгнэлт гарсан.</p> <p>Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах металлурги-химийн үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн байгуулалтын ажлыг оновчтой зохион байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад "China ENFI Engineering Corporation"-д дэмжлэг үзүүлэх хүсэлтийг БНХАУ-ын холбогдох төрийн байгууллагад зохих журмын дагуу уламжлах хүсэлтийн УУХҮ-ийн сайдын 2022.11.10-ны өдрийн 01/2938 дугаар албан бичгээр БНХАУ-аас Монгол</p>	30
----	--	---	-------------	---	----------	---	--	----

						Улсад суугаа элчин сайд Цай ВэньРуй-д хүргүүлсэн. China Enfi engenering corpration-аас 2022.11.15-ны өдөр ирүүлсэн албан бичигтээ туршилтын үйлдвэрийг 2023.05.30-ны өдөр барьж дуусган, туршилтын ажлын үр дүнг 2023.06.30-ны өдрийн дотор гаргасан байх тухай албан ёсоор мэдэгдсэн.	
42	6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна.	2020 - 2022	УУХҮЯ, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	745.2	Үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж дуусгана. 100%	SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн ба Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсний дагуу Техникийн зөвлөлийн 2022.11.02, 04-ний өдрүүдийн хурлаар хэлэлцэж ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхийг гүйцэтгэгч компанид хариуцуулж, гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах"-аар шийдвэрлэсэн байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30%-тай байна.	30
43	7. Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна.	2021 - 2024	УУХҮЯ, "Эрдэнэс Алт ресурс" ХХК		Үйлдвэрийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж, тоног төхөөрөмж худалдан авалтыг хийнэ. 30%	Төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны I улиралд багтаан зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах талаар УУХҮ-ийн сайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаартай албан бичгийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хүргүүлсэн. Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн захирлын 2022.03.21-ний өдрийн А-22/03 тушаалаар байгуулсан. Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамнаас 2022.07.18-ны өдрийн 30-309 дугаартай захидлаар "Сымбат инженеринг" ХХК нь алт цэвэршүүлэх үйлдвэр барихад шаардагдах санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтойг уламжилсан саналд "Эрдэнэс алт ресурс" ХХК нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хүлээн авч бүх талаар хамтран ажиллах саналаа 2022.08.31-ний өдрийн EA22/65 албан бичгээр илэрхийлсэн. Тус төслийн ТЭЗҮ боловсруулсан Бүгд Найрамдах Казахстан Улсын "Сымбат инженеринг" ХХК-ийн захирал Мейрам Тлеужанов 2022.11.21-23-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, "Эрдэнэс алт ресурс" ХХК-тай уулзалт хийсэн.	30

44		9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.	2021 - 2028	УУХҮЯ		Нарийвчилсан ТЭЗҮ, БОННУ, инженер, геологийн судалгааг хийнэ. 1%	Төслийн "Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал" болон "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг /USAID/-ийн Азийн Товчооны гэрээ хэлцлийн түншүүдтэй хамтран олон улсад мөрдөгдөж байгаа жишиг аргачлалын дагуу боловсруулахаар 2022.07.01-ний өдрөөс 2022.11.25-ны өдрийн хооронд хамтран ажилласны хүрээнд "Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал" болон "Хөрөнгө оруулалтын гэрээ"-ний төслийн сүүлийн хувилбарыг Англи, Монгол хэл дээр 2022.11.28-ны өдөр акт үйлдэн хүлээн авахаар тохиролцоод байна. Төсөлд шалгарсан хөрөнгө оруулагч нь төслийн нарийвчилсан ТЭЗҮ, инженер геологийн судалгааг хийхээр төслийн сонгон шалгаруулалтын аргачлалд тусгагдсан.	30
45		1.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		Шинээр 3 талбайд БХГ байгуулсан байна. ГТ-ны олборлолт 834.3 мян.тн	Матад ХХ талбайн газрын тосны нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн. 2022 онд нийт 6.28 сая баррель буюу 851 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2022.01.01-2022.12.20 хүртэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 2 098 172 баррель буюу 284 295 тонн газрын тос олборлож, 2 131 376 баррель буюу 289 475 тонн түүхий тос БНХАУ-д экспортлох төлөвтэй байна.	50
46	3.2.8. Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна:	1.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул судалгааны ажил, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлно	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл хийх 12 гэрээ хэрэгжиж байна. Хайгуулын 10 талбайд төлөвлөгөө төсөв баталсан. Эдгээр талбайд 2022 оны төлөвлөгөөгөөр нийтдээ 33.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр байна.	70
47		1.3. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		Шинээр 3 талбайд БХГ байгуулсан байна.	1. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулаад байна. 2. Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-т заасны дагуу хайгуулын нээлттэй талбайнууд хамарч буй 14 аймгийн ИТХ-аас санал, дүгнэлт авахаар албан бичиг хүргүүлсэн. Одоогийн байдлаар 5 аймгийн ИТХ хуралдаж тогтоол ирүүлээд байна. Төв, Ховд, Дорнод аймгийн ИТХ дэмжээгүй бөгөөд Өвөрхангай, Увс аймгийн	30

		оруулалтыг нэмэгдүүлнэ				ИТХ хуралдаж хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахыг дэмжсэн. Үүнтэй холбогдуулан дэмжсэн тогтоол ирүүлсэн хайгуулын талбайд сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг хийж байна. 3. Газрын тосны хайгуулын Гурванбаян-ХХХ талбайд БХГ байгуулахаар Баян петролиум ХХК-тай хэлэлцээрээр тохиролцсон гэрээний төсөлд яамдуудаас санал авч байна. Одоогийн байдлаар 17 санал ирсэн бөгөөд ЭЗХЯ-аас санал ирүүлээгүй байна. Саналыг нэгтгэж, холбогдох өөрчлөлтийг хийх, гэрээг эцэслэхээр АМГТГ-т саналыг хүргүүлээд байна. Саналыг нэгтгэж дуусгаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.		
48		1.4. Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		Гэрээлэгчдийн хайгуул, судалгааны ажлын үр дүнтэй уялдуулан нөөц тогтоох ажлыг зохион байгуулсан байна.	Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар 2022.04.27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулга хийж 25 дугаар тэмдэглэлийг гаргуулсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг БХБСайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан. Газрын тосны хайгуулын талбайнуудад цаашид нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 талбайн мэдээллийг 2022.05.18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулсан.	90
49		1.5. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		ГТ-ны олборлолт 836.4 мян.тн	Газрын тосны экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээлгэх талаар Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт 2022.04.08-ны өдрийн 1/935 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 тоот тогтоол гарсан. Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ-г хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022.05.19-ний өдрийн 78 дугаар захирамж гарч Ажлын	30

						хэсгийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулан ажиллаж байна. 2022 онд нийт 6.28 сая баррель буюу 851 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2022.01.01-2022.12.20 хүртэл хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 2 098 172 баррель буюу 284 295 тонн газрын тос олборлож, 2 131 376 баррель буюу 289 475 тонн түүхий тос БНХАУ-д экспортлох төлөвтэй байна.	
50	2.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 40%	УУХҮЯ-ны ТНБДаргын 2021 оны А/08 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг олон улсын сонгон шалгаруулалтыг явуулж БНХАУ-ын Норинко интернейшнл компанийг шалгаруулсан. Шалгарсан компанитай гэрээ байгуулах талаар ЗГ-ын 2022.03.02-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэл, 94 дүгээр тогтоолыг тус тус гаргуулж, хоолойн байгууламж барихад шаардагдах санхүүжилтийг нүүрс урьдчилан борлуулах замаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу Төслийн захиалагч Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, төслийн санхүүжүүлэгч “ЭТТ” ХК, төсөл хэрэгжүүлэгч “МГТБҮ” ТӨХХК болон төслийн гүйцэтгэгч БНХАУ-ын төрийн өмчит Норинко компаниудын хооронд 2022.04.18-ны өдөр Хамтран ажиллах гэрээг, “МГТБҮ” ТӨХХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.21-ний өдөр дамжуулах хоолойн инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх (ЕРС) гэрээ, “МГТБҮ” ТӨХХК болон “ЭТТ” ХК-ийн хооронд 2022.04.22-ны өдөр дамжуулах хоолойн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн гэрээг, “ЭТТ” ХК болон “Норинко” компанийн хооронд 2022.04.22-ны өдөр нүүрс худалдах, худалдан авах гэрээг тус тус байгуулсан.	50
51	2.3. Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна	2020 - 2024			Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 40 %	Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан “Улсын тусгай хэрэгцээ”-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 12-р сарын хурлаар тус аймагт хамаарах дамжуулах хоолойн газрын асуудлыг хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум, Халзан сум, Дорноговь аймгийн Дэлгэрэх сум, Дорнод аймгийн Матад сумын ИТХ-ын шийдвэрээр халаах-өргөх станцуудын хэрэгцээнд газар олгохыг дэмжсэн шийдвэр гарсан. Газрыг гэрчилгээжүүлэхээр газар эзэмших хүсэлт, дагалдах баримт бичгийн бүрдэлийг хангаж тус сумдын Засаг дарга болон газрын албанд хүргүүлээд байна. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхүүлээд барилга угсралтын ажил -35%, түр замын ажил -15%, Геодезийн цэг	30

						тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -60%, геотехникийн судалгааны ажил -80%, дээжлэлт шинжилгээ -80%. Тосон-Уул 19, Тамсаг XXI талбайн нэгдсэн байгууламжаас 17,5 л ба 16,7л дээж авч тосны дээж авсан. Тус дээжийг БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторт илгээсэн, хариу хүлээгдэж байна. Канад улын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлыг 2022.10.15-ны өдрөөс эхлүүлээд ажил -25% байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННУ хийх ажил -90% хийгдэж байна.	
52	3.1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	2020 - 2024			2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. 60%	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-80,68%, Хоолны газар-89,82%, Лаборатори-89,17%, Эмнэлгийн барилга-83,84%, Агуулах-58,47%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-51,0%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.	70
53	3.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах	2020 - 2024			Хууль батлагдсан байна. 100%	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг	100

		ажлыг зохион байгуулна				УИХ-ын чуулганы 2021.01.29-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан. Мөн хуулийн 3.3 дахь хэсэгт заасан Газрын тос боловсруулах үйлдвэрт төрөөс дэмжлэг үзүүлэх журмыг ЗГ-ын 2021.08.11-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор батлуулсан.		
54		3.3. Үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ	2020 - 2024			2020-2021 онд хийж эхэлсэн барилгаугсралтын ажлуудыг дуусгаж, лицензит байгууламжийн барилгаугсралтын ажлыг эхлүүлсэн байна. 60%	Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ний өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-2, ЕРС-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Mera инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан.	50
55		3.4. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах ажлыг зохион байгуулна	2020 - 2024			Шатахууны хангамж тогтвортой байна. 2.2 сая тонн	2022.10.22-ны өдрийн байдлаар Монгол Улсад нийт 1.6 сая гаруй тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсон. Үүнд 90-ээс доош октантай автобензин 31.2 мян.тонн, 90-ээс дээш октантай автобензин 578.8 мян.тонн, дизель түлш 846.6 мян.тонн, ТС 1 онгоцны түлш 33.2 мян.тонн, бусад бүтээгдэхүүн 177.2 мян.тонн тус тус импортолсон. 2022.11.22-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд дунджаар А-80 автобензин 37 хоног, Аи-92 автобензин 37 хоног, Аи-95 автобензин 31 хоног, дизель түлш 11 хоног, ТС-1 онгоцны түлш 38 хоногийн ердийн хэрэглээтэй тэнцэх үлдэгдэл, нөөцтэй байна. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлт тогтвортой байна.	90
56		3.5. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна	2020 - 2024			Евро-5 стандартын шатахууны хэрэглээ 25 хувьд хүрсэн байна.	Монгол Улс 2022.11.21-ний байдлаар нийт 1,456,818.6 тонн шатахуун импортолсон. Үүнд: дизелийн түлш 846,626.1 тонн, автобензин 578.866.5 тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын автобензин 148,998 тонн, дизелийн түлш 156,446.3 тонн, бүгд 305,444 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 21 %-ийг эзэлж байна. Монгол, Оросын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын ээлжит 24 дүгээр хуралдаан 2022.11.15-17-ны өдрүүдэд хуралдаж, протоколд “К5/Евро-5/ ангиллын бүтээгдэхүүний нийлүүлэлтийг боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх асуудлыг онцгой анхаарч, дэмжлэг үзүүлж	90

						хамтран ажиллах” саналыг тусгасан. Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандарт, хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд УУХҮЯ болон БНСУ-ын Газрын тосны чанар, хангамжийн газар (К-Петро) хооронд техник хамтын ажиллагааны санамж бичгийг 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан.	
57	3.6. Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2024	УУХҮЯ, АМГТГ		ТЭЗҮ-г боловсруулж, батлуулсан байна. 20%	Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад талд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийж байна.	50
58	3.7. Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа	2020 - 2024			Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулах асуудлыг шийдвэрлэсэн байна. 20%	ЗГХЭГ-ын дарга болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарын 2021.02.26-ны өдрийн 16-А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын хэсэгт ажилласан. Үүнтэй холбогдуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит “Эрчис Ойл” ХХК, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ, “Эрдэнэс метан” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүдийг нэгтгэн зохион байгуулж, газрын тосны хайгуул, судалгаа ашиглалт, боловсруулалт, хангамжийн үйл ажиллагаа явуулах төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг ажлын хэсгийн дүгнэлт болон Засгийн газрын шийдвэрийн төсөлд тусгуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2021.02.17-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавартай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд 2021.03-р сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлагатай хийсэн уулзалтын ярианы сэдэвт газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит	50

		явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна					компаниудыг нэгтгэн зохион байгуулж, төрийн өмчит үндэсний компани байгуулах асуудлыг тусгуулан, хэлэлцүүлсэн.	
59	3.5.2. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийг дуусгаж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл хангана.	1. Монгол улсын газар нутгаар дайруулан татах хийн хоолойн судалгааг хийнэ.	2021 - 2024	Эрдэнэс Монгол ХХК, УУХҮЯ ЭХЯ		Судалгааны ажил үргэлжлэн хийгдэнэ	Хийн хоолойн ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлын хүрээнд трассын дагуу байрших ашигт малтмалын илрэл, тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг хүргүүлсэн. Судалгааны ажил дууссан бөгөөд ТЭЗҮ-ийг тусгай зориулалтын компани “Газопровод Союз Восток” ХХК 2021.12.15-ны өдөр монголын талд хүлээлгэн өгсөн. 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан болон “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов нар Монгол Улсын Засгийн газар болон “Газпром” НХН-ийн Хамтарсан ажлын хэсгийн 2022–2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж тус төлөвлөгөөний дагуу 2022.02.28-ны өдөр инженерийн хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудын даалгаврыг баталж “Газопровод Союз Восток” ХХК блон “Газпром Проектирование” ХХН-ийн хооронд инженер хайгуул судалгаа, зураг төслийн ажлуудыг гүйцэтгэх Гэрээнд гарын үсэн зурсан. Үүний дагуу 2022.04.28-ны өдөр инженерийн хайгуул судалгааны ажил эхэлж, судалгааны ажил хэвийн явагдаж байна. 2023 онд тус төслийг гүйцэтгэхэд ОХУ-аас 30 ажилтан ажиллахаар төлөвлөсөн бөгөөд эдгээр хүмүүст Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгуулахаар НХХЯ-д дэмжлэг үзүүлэх тухай 2022.10.24-ний өдрийн 03/2779 албан бичгийг хүргүүлсэн.	100
60	3.6.3. Зорилт	2.1. Цахилгаан болон байгалийн хийн хөдөлгүүртэй тээврийн хэрэгслийн цэнэглэх сүлжээг ШТС, үйлчилгээний газруудыг түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.	2021 - 2024	ЗТХЯ, УУХҮЯ ТХААГ, ХХ		Цахилгаанаар цэнэглэх 12 цэг, хийгээр цэнэглэх 6 станц	Байгалийн хийн импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч Юу Би Метан ХХК нь 2021 онд 1000 тонн шахсан байгалийн хий импортлон, нийслэлийн нийтийн тээврийн 100 орчим хийн хөдөлгүүртэй автобусыг цэнэглэх үйл ажиллагаа явуулсан. Тус компани 2021 онд Баянзүрх дүүргийн Монелд тээврийн хэрэгслийг байгалийн хий, ШШХ, шатахуунаар цэнэглэх станц барьж байгуулахаар зураг, төслийг батлуулан, эхний хэсгийг УОК-т хүлээлгэн өгсөн. Мөн Сонгинохайрхан дүүргийн Рашаант өртөөнд байгалийн хийн агуулах, хий цэнэглэх станц барих төслийг хэрэгжүүлж, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл 80 гаруй хувьтай явагдаж байна.	70

61		1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ,	132470.6 сая төгрөг ТӨҮГ-ын хөрөнгөөр	Арматур цувах, ган утас үйлдвэрлэх шугамыг барьсан байна.	“Бэрэн групп” ХХК болон түүний хамаарал бүхий компаниудын Хөгжлийн банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас 2022 оны 8 дугаар сард Хууль хяналтын байгууллагад хүргүүлсэн. Уг асуудлын хүрээнд шийдвэр гарч, барьцаа хөрөнгө өр, зээлийн асуудал шийдэгдэх хүртэл төслийн ажил зогсонги байдалд байна.	30
62	3.7.13. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.	2. Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулж ашиглалтад оруулна.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, НЗДТГ		Шилний үйлдвэр барих төсөл боловсруулж холбогдох газарт хүргүүлнэ.	Үндсэн түүхий эдийн нэг болох Налайхын Элстэйн цахиурын элсний ордын ТЭЗҮ-ийг 2022.03.22-ны өдөр УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн, мөн БО-ны нарийвчилсан үнэлгээний тайланг БОАЖЯ-ны БОУ-ний комиссын хурлаар 2022.06.07-нд хэлэлцүүлэн батлуулсан. Энэ ордын ашиглалтад шаардлагатай байгаа цахилгаан эрчим хүчний Техникийн нөхцөл олгогдохгүй байгаатай холбогдуулан Техникийн нөхцөл олгоход дэмжлэг үзүүлэх тухай хүсэлтийг 2022.06.15-ны өдрийн 3/2885 тоотор “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д хүргүүлсэн. Биелэлт нэмэгдээгүй.	30
63		3. Баруун бүсэд Ховд-Эко цементийн үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2020 - 2024	Хувийн хэвшэл, БХБЯ, УУХҮЯ, Ховд аймгийн ЗДТГ		Цементийн үйлдвэрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	Ховд эко цементийн үйлдвэрийн төслийг “Вестерн холд” ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү үйлдвэр ашиглалтанд орсноор баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах юм. Цар тахалтай холбоотойгоор төслийн ажлын явц тодорхой хугацаагаар хойшилсон ч жилд 300 мянган тонн цемент үйлдвэрлэж, баруун бүсийн цементийн хэрэглээг бүрэн хангах хүчин чадалтай “Ховд эко цемент”-ийн үйлдвэр 2022.10.28-ны өдөр ашиглалтад орсон.	100
64		4. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ Хамтрагч нь БХБЯ		Ашигт малтмалын тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн хэрэгжилтийн байдалд судалгаа хийнэ.	Эрх зүйн тусгайлсан хэрэгцээ шаардлага бий эсэхийг тодруулах зорилгоор Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн бусад холбогдох хуулиудтай зөрчил, давхардал, хийдэл байгаа эсэхийг тогтоож, тодруулах судалгааг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. Энэхүү судалгааны үр дүнд Түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой харилцааг зохицуулах тусгайлсан хууль шаардлагагүй гэдэгт тогтоогдсон байна. Иймд энэхүү асуудлыг тусган Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улмаар УИХ-д өргөн мэдүүлсэн боловч байнгын хороодоор хэлэлцэх явцад хуулийн төслийг дахин боловсруулахаар буцаасан. Мөн Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлт орсон. Эдгээр чиглэл болон эрх зүйн өөрчлөлтүүдтэй уялдуулан Хуулийн төслийг дахин боловсруулах үүрэг	50

							бүхий Ажлын хэсгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2020 оны А/332 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, түүнд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 17 дугаар тогтоол гарсан.	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
65	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024	Яамд, ТАЗ, УАкадеми		Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугамаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 12 албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2022 оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	100
66	4.3.17. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй	1. Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал,	2020 - 2022	УУХҮЯ Хамтрагч нь МХЕГ		Газрын тосны бүтээгдэхүүн, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал,	Улсын Их Хурал 2020.01.30-ны өдөр Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д 2020 оны 174 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан. Мөн Улсын онцгой комиссын 2020 оны 35 дугаар тэмдэглэлийн 3.6-д “уул уурхайн зориулалттай сэлбэг хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бараа материалын тээвэрлэлт, түгээлтийг халдвар хамгаалалын	100

	байдал, хяналтыг сайжруулна.	хяналтыг сайжруулна.				хяналтыг сайжруулна.	дэглэмийг сайтар мөрдөж, ариутгал, халдваргүйжүүлэн холбогдох хууль тогтоомжийн дагуу аймг, нийслэл, орон нутагт саадгүй нэвтрүүлэх” заалтыг тусгуулж шийдвэрлүүлсэн. Газрын тосны хайгуул, олборлолтын чиглэлээр ашиглах тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, ашиглах тусгай зөвшөөрөл олгох асуудлыг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байна. Уг тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж байна.	
67	4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.	4. БНЭУ-тай Стратегийн түншлэлийг улам бэхжүүлж, БНЭУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	2021 - 2024	УУХҮЯ, СЯ Хамтрагч ГХЯ		Үйлдвэрийг барьж байгуулахаар хэрэгжүүлж буй төсөлд тодорхой ахиц гарсан байна.	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-80,68%, Хоолны газар-89,82%, Лаборатори-89,17%, Эмнэлгийн барилга-83,84%, Агуулах-58,47%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-51,0%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /ЕРС-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /ЕРС-3/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. ЕРС-2, ЕРС-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Mera инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс техноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. Лицензтэй	100

							технологийн байгууламжийн Инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгох тендерийн баримт бичиг боловсруулж байна.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
68	5.1.8. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8 мянган га талбайг нөхөн сэргээнэ.	1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээнэ.	2020 - 2024	УУХҮЯ, АНЗДТГ, БОАЖЯ МХЕГ	84,0 сая төгрөгөөр Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 2000 га талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	2022 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлт 507.7 га-д, биологийн нөхөн сэргээлт 306.2 га-д, дүйцүүлэх хамгаалах ажил 1388.8 га-д нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. “Оюу толгой” ХХК Ялбаг орчмын 334.57 га, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 500 га талбайд нөхөн сэргээлтийн тендер зарлагдаж сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. Нийслэлийн ЗДТГ-аас Налайх дүүргийн 3-р хороонд нүүрсний олборлолтын улмаас эвдрэлд орсон 40 га газрын нөхөн сэргээх ажлын тендер зарласан. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3 дугаар заалтын дагуу 2022 оны уулын ажлын гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2-р сард ирүүлдэг. 2022 оны хагас жилийн мэдээлэл гаргах боломжгүй байна.	70

69	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024	БОАЖЯ, ЭХЯ, БХБЯ, ЗТХЯ, СЯ, ХХААХҮЯ, УУХҮЯ ОБЕГ, АНЗДТГ, ҮХГ	Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулна.	Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр, зорилт арга хэмжээг тодорхойлох баримт бичгийг боловсруулах үүрэг бүхий Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт тус яамнаас холбогдох албан тушаалтнууд ажилласан болно. Ажлын хэсгээс Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд өчүүхэн (0.09%) хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их байгааг тогтоосон. Мөн 2014 онд нийт 34482.73 мян.тн CO2 ялгаруулсны 50.08% нь эрчим хүч, 48.51% нь хөдөө аж ахуй, 0.95% нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Эрчим хүчний салбарын хүлэмжийн хийн ялгаралд 2020 онд нүүрсий олборлолт 4.9%-ийг эзэлж байна. Дээр дурдсан баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нүүрсний уурхайн метан хийг ашиглах асуудлыг 2025-2030 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан болно. Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг нэгтгэн боловсруулж, УУХҮ-ийн сайдын 2020.11.25-ны өдрийн 01/2909 дүгээр албан бичгээр Сангийн яам болон ХЗДХЯ-нд, агаарын чанарыг сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох талаар Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан 2020.09.24-ний өдрийн 01/2345 тоот албан бичгээр БОАЖЯ-нд тус тус хүргүүлсэн.	100
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН						62.32	